БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/164/НА-СТА-ТШЗ**

Баянхонгор
2022 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Аудитор: Ж.Өсөхбаяр

Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт ..... 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
3. Аудитын тайлан ..... 9
3.1 Ерөнхий зүйл ..... 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Материаллаг байдал ..... 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 11
3.8 Аудитын гол асуудал ..... 12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 13
4. Аудитын илрүүлэлт ..... 14
4.1 Албан шаардлага ..... 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 14

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/98

танай ________ -ны № ________ -т

БАЯНХОНГОР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЭРДЭНЭМАНДАЛ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Л.ОНОНХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

005020471

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **266,162,304.68** | **321,529,082.68** |
| **33** | **АВЛАГА** | 6,301,608.00 | 6,339,408.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 37,800.00 |
| **335** | **Бусад авлага** | 6,301,608.00 | 6,301,608.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 6,301,608.00 | 6,301,608.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 259,860,696.68 | 315,189,674.68 |
| **351** | **Түүхий эд материал** | 78,712,617.36 | 96,947,410.36 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 70,118,467.36 | 77,401,430.36 |
| 35130 | Эм боох материал | 8,594,150.00 | 19,545,980.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 181,148,079.32 | 218,242,264.32 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,394,630.00 | 12,032,567.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,845,350.00 | 7,547,057.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 28,237,600.00 | 33,251,530.00 |
| 35460 | Хүнсний материал | 00.00 | 448,350.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 142,670,499.32 | 164,962,760.32 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,037,236,035.73** | **3,933,392,563.80** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,037,236,035.73 | 3,933,392,563.80 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,401,786,035.73 | 3,297,942,563.80 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,383,870,267.36 | 3,384,670,267.36 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -265,914,696.20 | -399,755,162.54 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 278,237,708.22 | 298,435,311.22 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -194,566,731.70 | -197,520,373.51 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 266,178,434.75 | 284,664,615.55 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -140,492,107.70 | -149,117,255.28 |
| 39217 | Ном | 74,473,161.00 | 76,565,161.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 635,450,000.00 | 635,450,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -550,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 635,450,000.00 | 635,450,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **4,303,398,340.41** | **4,254,921,646.48** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **4,303,398,340.41** | **4,254,921,646.48** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 4,303,398,340.41 | 4,254,921,646.48 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,468,610,681.55 | 1,468,610,681.55 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,468,610,681.55 | 1,468,610,681.55 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 800,018,014.81 | 751,541,320.88 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 800,018,014.81 | 800,018,014.81 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -48,476,693.93 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,034,769,644.05 | 2,034,769,644.05 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **4,303,398,340.41** | **4,254,921,646.48** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,452,334,710.50** | **2,464,886,304.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **186,100,531.50** | **64,014,810.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 186,100,531.50 | 64,014,810.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 186,100,531.50 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 186,100,531.50 | 00.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 00.00 | 44,603,310.80 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 0.00 | 19411500.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,266,234,179.00** | **2,400,871,494.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,798,187,100.00 | 1,803,510,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,798,187,100.00 | 1,803,510,000.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 49,264,279.00 | 173,395,594.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 43,575,279.00 | 173,395,594.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,689,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 418,782,800.00 | 423,965,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 418,782,800.00 | 423,965,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,355,412,143.63** | **2,513,362,998.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,355,412,143.63** | **2,513,362,998.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,245,747,458.84 | 2,318,157,283.48 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,399,813,772.00 | 1,456,323,319.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,076,001,183.00 | 1,221,750,119.00 |
| 210102 | Нэмэгдэл | 153,375,356.00 | 145,256,200.00 |
| 210104 | Урамшуулал | 170,437,233.00 | 89,317,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 177,622,628.79 | 188,850,180.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 122,653,680.00 | 132,344,570.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,870,063.00 | 14,685,253.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,038,932.00 | 11,714,602.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,549,114.79 | 2,736,886.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,510,839.00 | 27,368,869.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 407,529,017.50 | 422,965,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,186,266.00 | 10,154,645.00 |
| 210302 | Түлш, халаалт | 342,924,719.50 | 357,096,223.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 55,418,032.00 | 55,715,032.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 70,944,874.80 | 20,453,474.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,287,930.00 | 1,638,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,199,500.92 | 5,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,783,400.00 | 4,652,843.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 454,600.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,415,800.00 | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,835,410.00 | 4,256,595.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 48,968,233.88 | 4,405,636.00 |
| **2105** | **Норматив зардал** | 2,440,450.00 | 640,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,155,750.00 | 640,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 284,700.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,202,450.00 | 24,097,070.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,202,450.00 | 24,097,070.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,758,000.00 | 950,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,758,000.00 | 950,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,686,800.00 | 2,372,477.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,086,800.00 | 1,532,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 239,877.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 175,749,465.75 | 201,504,762.73 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,463,900.00 | 11,708,880.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,464,420.00 | 4,696,100.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 167,821,145.75 | 185,099,782.73 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 109,664,684.79 | 195,205,715.25 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 77,128,094.00 | 194,744,169.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,908,015.00 | 31,435,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,136,869.00 | 123,236,069.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 28,438,410.00 | 38,935,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,644,800.00 | 1,138,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,253,782.50 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,253,782.50 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 31,282,808.29 | 461,546.25 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31,282,808.29 | 461,546.25 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **96,922,566.87** | **-48,476,693.93** |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **96,922,566.87** | **-48,476,693.93** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,266,234,179.00** | **2,400,871,494.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,266,234,179.00** | **2,400,871,494.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,798,187,100.00 | 1,803,510,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,798,187,100.00 | 1,803,510,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 49,264,279.00 | 173,395,594.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 43,575,279.00 | 173,395,594.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,689,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 418,782,800.00 | 423,965,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 418,782,800.00 | 423,965,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,201,903,696.00** | **2,364,218,494.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,201,903,696.00** | **2,364,218,494.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,092,239,011.21** | **2,168,564,428.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,399,208,627.00 | 1,455,556,299.75 |
| 210101 | Үндсэн цалин | 1,075,395,738.00 | 1,220,983,099.75 |
| 210102 | Нэмэгдэл | 153,375,656.00 | 145,256,200.00 |
| 210104 | Урамшуулал | 170,437,233.00 | 89,317,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 177,622,628.79 | 189,655,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 122,807,954.79 | 140,574,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,969,574.00 | 12,426,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,641,843.00 | 9,925,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,692,418.00 | 2,485,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 27,510,839.00 | 24,244,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 407,529,017.50 | 422,965,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,186,266.00 | 10,154,645.00 |
| 210302 | Түлш, халаалт | 342,924,719.50 | 357,096,223.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 55,418,032.00 | 55,715,032.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 25,816,680.92 | 22,014,067.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,198,700.00 | 2,193,950.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,199,500.92 | 5,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,783,400.00 | 4,652,843.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,308,500.00 | 69,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,415,800.00 | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,910,780.00 | 9,597,974.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 18,580,600.00 | 4,142,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5,872,300.00 | 640,100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,708,300.00 | 3,502,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 33,409,300.00 | 32,702,600.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 360,000.00 | 00.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 1,186,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 33,049,300.00 | 31,516,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,758,000.00 | 950,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,758,000.00 | 950,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,136,917.00 | 8,133,902.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,536,917.00 | 7,294,025.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 239,877.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,177,240.00 | 32,444,160.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,841,940.00 | 19,999,960.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,335,300.00 | 12,444,200.00 |

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **109,664,684.79** | **195,654,065.25** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 77,128,094.00 | 195,192,519.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,908,015.00 | 31,883,350.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,136,869.00 | 123,236,069.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 28,438,410.00 | 38,935,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,644,800.00 | 1,138,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,253,782.50 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,253,782.50 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 31,282,808.29 | 461,546.25 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 31,282,808.29 | 461,546.25 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **64,330,483.00** | **36,653,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **64,330,483.00** | **36,653,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **64,330,483.00** | **36,653,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 64,330,483.00 | 36,653,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 64,330,483.00 | 36,653,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-64,330,483.00** | **-36,653,000.00** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,468,610,681.55** | **2,034,769,644.05** | **800,018,014.81** | 4,303,398,340.41 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,468,610,681.55** | **2,034,769,644.05** | **800,018,014.81** | 4,303,398,340.41 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,468,610,681.55** | **2,034,769,644.05** | **800,018,014.81** | 4,303,398,340.41 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -48,476,693.93 | -48,476,693.93 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,468,610,681.55** | **2,034,769,644.05** | **751,541,320.88** | 4,254,921,646.48 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,227,475,900.00 | 2,227,014,353.75 | 461,546.25 | 99.98 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,227,475,900.00 | 2,227,014,353.75 | 461,546.25 | 99.98 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,194,040,400.00 | 2,193,993,003.75 | 47,396.25 | 100.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,455,602,400.00 | 1,455,556,299.75 | 46,100.25 | 100.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,221,029,200.00 | 1,220,983,099.75 | 46,100.25 | 100.00 |
| 210102 | Нэмэгдэл | 145,256,200.00 | 145,256,200.00 | 00.00 | 100.00 |
| 210104 | Урамшуулал | 89,317,000.00 | 89,317,000.00 | 00.00 | 100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 189,655,000.00 | 189,655,000.00 | 00.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 146,413,500.00 | 140,574,100.00 | 5,839,400.00 | 96.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,935,500.00 | 12,426,100.00 | -1,490,600.00 | 113.63 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,748,400.00 | 9,925,400.00 | -1,177,000.00 | 113.45 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,187,000.00 | 2,485,200.00 | -298,200.00 | 113.64 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,370,600.00 | 24,244,200.00 | -2,873,600.00 | 113.45 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 422,965,900.00 | 422,965,900.00 | 00.00 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,246,500.00 | 10,154,645.00 | 1,091,855.00 | 90.29 |
| 210302 | Түлш, халаалт | 352,919,400.00 | 357,096,223.00 | -4,176,823.00 | 101.18 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 58,800,000.00 | 55,715,032.00 | 3,084,968.00 | 94.75 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,302,100.00 | 43,302,067.00 | 33.00 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,185,800.00 | 2,193,950.00 | -8,150.00 | 100.37 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,000,000.00 | 5,000,000.00 | 00.00 | 100.00 |

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,407,300.00 | 4,652,843.00 | -245,543.00 | 105.57 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,811,000.00 | 1,557,300.00 | 253,700.00 | 85.99 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 500,000.00 | 00.00 | 100.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 29,398,000.00 | 29,397,974.00 | 26.00 | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,142,500.00 | 4,142,500.00 | 00.00 | 100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 640,100.00 | 640,100.00 | 00.00 | 100.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,502,400.00 | 3,502,400.00 | 00.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 42,285,900.00 | 42,285,600.00 | 300.00 | 100.00 |
| 210602 | Тавилга | 9,969,800.00 | 9,969,500.00 | 300.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,316,100.00 | 32,316,100.00 | 00.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 950,800.00 | 950,000.00 | 800.00 | 99.92 |
| 210702 | Дотоод албан томилолт | 950,800.00 | 950,000.00 | 800.00 | 99.92 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,691,600.00 | 2,691,477.00 | 123.00 | 100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,851,600.00 | 1,851,600.00 | 00.00 | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 600,000.00 | 00.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 239,877.00 | 123.00 | 99.95 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 32444200.00 | 32444160.00 | 40.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,000,000.00 | 19,999,960.00 | 40.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,444,200.00 | 12,444,200.00 | 00.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 33435500.00 | 33021350.00 | 414,150.00 | 98.76 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 33,435,500.00 | 33,021,350.00 | 414,150.00 | 98.76 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 32,297,500.00 | 31,883,350.00 | 414,150.00 | 98.72 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,138,000.00 | 1,138,000.00 | 00.00 | 100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,227,475,900.00 | 2,227,014,353.75 | 461,546.25 | 99.98 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,803,510,000.00 | 1,803,048,453.75 | 461,546.25 | 99.97 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,803,510,000.00 | 1,803,048,453.75 | 461,546.25 | 99.97 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 423,965,900.00 | 423,965,900.00 | 00.00 | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 423,965,900.00 | 423,965,900.00 | 00.00 | 100.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 00.00 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 116.00 | 116.00 | 00.00 | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 91.00 | 91.00 | 00.00 | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 25.00 | 25.00 | 00.00 | 100.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1,216.00 | 1,232.00 | -16.00 | 101.32 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1,216.00 | 1,232.00 | -16.00 | 101.32 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,216.00 | 1,232.00 | -16.00 | 101.32 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **117.00** | **117.00** | 00.00 | 100.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 83.00 | 83.00 | 00.00 | 100.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн йилчилгээний албан хаагч (ТҮСУ) | 01.00 | 01.00 | 00.00 | 100.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 01.00 | 01.00 | 00.00 | 100.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 32.00 | 32.00 | 00.00 | 100.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **49,264,279.00** | **173,395,594.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **49,264,279.00** | **173,395,594.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,689,000.00 | 11,224,425.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,689,000.00 | 11,224,425.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,689,000.00 | 11,224,425.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 43,575,279.00 | 162171169.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,575,279.00 | 162,171,169.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,136,869.00 | 123,236,069.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 28,438,410.00 | 38,935,100.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 49,264,279.00 | 173395594.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 49,264,279.00 | 173,395,594.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 43,575,279.00 | 173,395,594.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,689,000.00 | 00.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цэнням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 1/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Л.Ононхүү, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Ж.Янжмаа нар зурсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Багшийн хөгжлийг дэмжсэнээр хүүхдэд эерэг зан чанар, хандлагыг төлөвшүүлэн, тэдний мэдлэг эзэмших чадварыг хөгжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,355,412.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,554.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 16,487.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд, 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход гүйцэтгэлийн материаллаг байдал  26,390.3 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 48,476.7 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн  данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| A | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 266,162.3 | 321,529.1 | 55,366.8 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 6,301.6 | 6,339.4 | 37.8 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 259,860.7 | 315,189.7 | 55,329.0 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 4,037,236.0 | 3,933,392.6 | (103,843.5) |
| Үндсэн хөрөнгө | 4,638,759.6 | 4,680,335.4 | 41,575.8 |
| Хуримтлагдсан элэгдэл | (601,523.5) | (746,942.8) | (145,419.3) |
| **Нийт хөрөнгө** | **4,303,398.3** | **4,254,921.6** | **(48,476.7)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 4,303,398.3 | 4,254,921.6 | (48,476.7) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **4,303,398.3** | **4,254,921.6** | **(48,476.7)** |

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 37.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь өмнөх онд ажиллагсадтай холбоотой өндөр насны тэтгэвэрт гарсан 4 иргэнд олгосон 6,301.6

мянган төгрөгийн авлага барагдаагүй байгаа бол тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн 37.8 мянган төгрөгийн авлага үүссэнийг бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 315,189.7 мянган төгрөг болж 55,329.0 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал дансны үлдэгдэл 7,283.0 мянга, эм боох материал дансны үлдэгдэл 10,951.8 мянга, бичиг хэргийн материал дансны үлдэгдэл 7,637.9 мянга, аж ахуйн материал дансны үлдэгдэл 1,701.7 мянга, барилгын засварын материал дансны үлдэгдэл 5,013.9 мянга, бусад хангамжийн материал дансны үлдэгдэл 22,292.3 мянган төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,680,335.4 мянган төгрөг болж өмнөх оноос 41,575.8 мянган төгрөгөөр өссөн нь 36,653.0 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, хандив тусламжаар 604.0 мянга, үнэ төлбөргүй 43,999.3 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч бүртгэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 20 дугаар тогтоолын дагуу 38,836.6 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 2021 оны 139 дүгээр тогтоолын дагуу 843.9 мянган төгрөгийн хөрөнгийг аймгийн Боловсролын газрын дэргэдэх Насан туршийн боловсролын төвд шилжүүлсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,254,921.6 мянган төгрөг болж 48,476.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 48,476.7 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 3,233,839.8 мянга, санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,233,839.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бараа, ажил үйлчилгээний зардлыг 953,136.2 мянга, урсгал шилжүүлгийг 236,188.6 мянга нийт 1,189,324.8 мянган төгрөгөөр бууруулж 2,044,515.0 мянган төгрөгөөр анх батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 2,227,475.9 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,803,510.0 мянга, орон нутгийн төсвөөс 423,965.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,227,014.4 мянган төгрөгийг зарцуулж 461.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,227,014.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 46.1 мянга, үдийн цайны зардлыг 461.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа БШУЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор хичээллэсэн.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд нийт 108 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 95.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 2,513,63.0 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 157,950.9 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, дотоод албан томилолтын зардал, эд хогшил худалдан авах зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 3,532,174.9 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

**Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна.Үүнд:

- 2021 оны төсвийг 2,044,515.0 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 182,960.9 мянган төгрөг нэмж 1,803,510.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 423,965.9 мянган төгрөгийн мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан ба гүйцэтгэлээр 2,227,014.4 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 0.1 хувийн хэмнэлт гаргасан. Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын төсвийг 634,151.5 мянган төгрөгөөр анх баталсан ба тодотголоор 51,933.0 мянган төгрөг хасаж 582,218.5 мянган төгрөгөөр баталсан ба гүйцэтгэлээр 581,803.0 мянган төгрөг зарцуулсан байгаа нь батлагдсан төсөвт 8.3 хувийн хэмнэлт гаргасан.

- Байгууллагын байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 435,827.2 мянган төгрөгөөр, тодотголоор 422,965.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 412,811.2 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 23,015.9 мянган төгрөг буюу 5.3 хувь хэмнэсэн.

- Бичиг хэргийн зардлыг 215.2 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 2,193.9 мянган төгрөг зарцуулж төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Эдгээр нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8, 1.9 дэх заалтуудтай нийцээгүй байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 24,160.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 24,160.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлж ажиллах 1 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байгаа ч өмнөх оны авлага барагдуулах тухай 6,301.6 мянга, төрийн албан хаагчийн буруутай үйлдлийн улмаас төрд учруулсан хохирлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх 17,858.7 мянган төгрөгийн албан шаардлага биелээгүй байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчин төрийн үйлчилгээний албан хаагч Л.Ононхүүд төсвийн зардлаас цалин, НДШ-д 17858.7 мянган төгрөг олгосон зөрчилд өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд төрд учирсан хохирлыг барагдуулах албан шаардлага өгсөн, биелэгдээгүй байгаа тул завсрын аудитаар анхаарч үзэх.

2. Аймгийн Засаг даргын 2021.12.06-ны өдрийн А/742 тоот захирамжаар тус байгууллагын төсөвт зардлыг нэмэгдүүлэн бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс авах зардлын төсвийг 27,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж зохицуулалт хийсний дагуу Санка Маркетинг Монголиа ХХК-иас 19,800.0 мянган төгрөгийн ухаалаг самбар худалдан авсан байгаа тул аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар анхаарч үзэх.

3. Өндөр насны тэтгэвэрт гарсан 4 иргэнд олгосон 6,301.6 мянган төгрөгийг авлагын тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгснийг хэрэгжүүлээгүй байгаа тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн эсэхийг завсрын аудитаар анхаарч үзэх.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 11,074.8 мянган төгрөгийн 1 алдаа зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүллээ.

### 4.1 Албан шаардлага

1. Тайлант онд тус байгууллага нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлээс бусад урсгал зардлын батлагдсан төсөвт 8.3 хувийн хэмнэлт гаргасан, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 5.3 хувь хэмнэсэн, бичиг хэргийн зардлыг 8.1 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1, 1.8, 1.9 дэх заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль тогтоомж шийдвэрийг цаашид мөрдөж ажиллах албан шаардлага өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баянхонгор сумын ерөнхий боловсролын Эрдэнэмандал сургууль | 1 | 11074.8 | | | | | 1 | 11074.8 | - | - |

______oOo______